**НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР ХИЙГДСЭН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ**

202 оны 01 дүгээр сарын 04 Улаанбаатар хот

| Зорилт | № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин (Тоо хэмжээ, хувь) | Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ) | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг) | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1.Хүний нөөцийг чадавхжуулах | 1 | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт | Дотоод сургалтын тоо | 18– с дээш | 100 хувь | Хөрөнгө зарцуулаагүй | Байгууллагын хүрээнд ажилтан, албан хаагчдыг ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах, хөгжүүлэх зорилгоор төлөвлөгдсөн танхимын сургалтууд хийгдээгүй болно.<br>• Нийслэлээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажилтан албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хамгаалах зорилгоор "Коронавируст (COVID-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх" талаар<br>✓ гар угаах зааварчилгаа,<br>✓ ариутгал, цэвэрлэгээ хэрхэн хийх ,<br>✓ агаар сэлгэлтийг хэрхэн хийх<br>✓ ам хаалт зүүхийн ач тус гэх мэт сургалтыг 1 дүгээр сараас өнөөдрийг хүртэл Халдварт өвчин судлалын үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг ашиглан цахим сургалт, мэдээллийг тогтмол хүргэж ажиллав.<br>• Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Коронавируст (COVID-19) цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын хүрээнд “Аваарын бүлэг”-ийг хэрхэн томилох, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, дайчилгаанд ажиллуулах нөөц тээврийн хэрэгслийг бэлтгэх, жолооч нарыг тусгай хувцас хэрэгслээр ханган зам, тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээний сургалт Нийслэлийн Онцгой байдлын газрын өгсөн заавар зөвлөмжийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд гамшгийн бодит нөхцөл байдлын талаарх мэдээлэл, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх аргачилал, аюулгүй ажиллагааны талаарх сургалтад албан хаагчдаа хамруулан, мэдээлэл өгч ажиллалаа.<br>2.Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар, Мэдээллийн технологийн газраас хамтран зохион байгуулсан иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүртгэн авах, түргэн шуурхай хэрхэн шийдвэрлэх www.erp.ulaanbaatar.mn мэдээллийн нэгдсэн сангийн сургалтад өргөдөл гомдол шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн хамрагдсан. |
| | | | Албан хаагчдын хамрагдсан байдал | 100 хувь | 100 хувь | Хөрөнгө зарцуулаагүй | 1.2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн "Онцгой байдлын болон гамшгаас хамгаалах байнгын ажиллагаатай орон тооны бус мэргэжлийн анги байгуулах тухай" А/27, 05 дугаар сарын 05-ны өдрийн "Дадлага сургуулилтын үед авах арга хэмжээний тухай" А/41 дүгээр тушаалууд, 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр "Нийслэлийн гамшгаас хамгаалах албадын гамшгийн асуудал хариуцсан ажилтнуудад дадлага, сургуулийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө" баталж, нийт хэлтэс, нэгжийн удирдлагууд үүрэг хүлээн хамрагдсан.<br><br>2.Тус байгууллагад хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг нэгдсэн систем /www.erp.ulaanbaatar.mn/-ээр хүлээн авч шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, нийслэлээс гаргах бодлого шийдвэрт иргэдийн санал бодлыг тусгах, шуурхай, ил тод байдлыг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс зохион байгуулсан сургалтад Эрх зүйч, Хүний нөөцийн мэргэжилтэн нар хамрагдсан.<br><br>3.Нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Хүний нөөцийн удирдлагын систем (ХНУС) дэх албан хаагчдын мэдээллийг шинэчлэх болон Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-д албан хаагчдын хамруулах сургалтад 2 албан хаагч хамрагдсан<br><br>4."Удирдлагын академи Мэргэшил дээшлүүлэх институт"-аас зохион байгуулж буй Төрийн албанд анх томилогдсон иргэнийг төрийн албаны онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4.“Удирдлагын академи Мэргэшил дээшлүүлэх институт”-аас зохион байгуулж буй Төрийн албанд анх томилогдсон иргэнийг төрийн албаны онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх зүйн болон төрийн албаны стандарт, шаардлагад нийцэн ажиллах мэдлэг ур чадвар эзэмшүүлэх зорилго бүхий 40 цагийн чиглүүлэх сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн;<br><br>5.“Маршрут удирдлагын программ” сургалтад ТТТХ-ийн График төлөвлөлтийн инженер, Сүлжээ, төлөвлөлт, судалгаа шинжилгээний мэргэжилтэн, Техник, технологи стандарт хариуцсан мэргэжилтэн, Зогсоолын төлөвлөлт хариуцсан ажилтан, График, зогсоол, мэдээллийн сан хариуцсан ажилтан, Тээврийн эдийн засагч нар хамрагдсан.<br><br>6.Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Жендэрийн сургалт”-д Хүний нөөцийн мэргэжилтэн;<br><br>7. Төрийн албаны Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системийг Төрийн албаны зөвлөл (ТАЗ) хариуцан ажилладаг бөгөөд системд мэдээллийн баяжилт хийх, ХНУС болон ТАЦНС хооронд мэдээлэл солилцох нь ЗГ-ын 2019 оны 74 тоот тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-аар зохицуулагддаг болсонтой холбоотойгоор байгууллагын албан хаагчдын нэгдсэн мэдээллийг хөтлөх, цалин хөлсийг бодож, олгох сургалтад Тооцооны нягтлан бодогч (цалингийн нягтлан бодогч), Хүний нөөцийн мэргэжилтэн нар 96 цагийн цахимаар хамрагдсан.<br>Энэ сургалтаар Хүний нөөцийн мэргэжилтэн нь олж авсан мэдлэгийн хүрээнд Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам: https://bit.ly/34pVhi0, ХНУС-д хандах холбоос: https://hr.csc.gov.mn/ -д ХНУС дэх мэдээллийн найдвартай байдлаас шалтгаалж албан хаагчдын шилжилт хөдөлгөөн, холбогдох өгөгдөл мэдээллийн өөрчлөлтийг системд тухай цаг алдалгүй тухай бүр оруулж шинэчлэснээр цалин хөлс цаг хугацаандаа, үнэн зөв тодорхойлогдон олгогдож байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 8. “Итгэл даах төрийн албаны төлөө” Ёс зүйн зөвлөлүүдийн нэгдсэн зөвлөгөөнд Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга хамрагдсан. |
| | | | Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал | 20 хувь | 20 хувь | Хөрөнгө зарцуулаагүй | Ковид гарсантай холбоотойгоор гадаад хамтын ажиллагаа, гадаад сургалт байхгүй.<br>1.Швейцарийн хөгжлийн агентлаг, ХБНГУ-ын Холбоны эдийн засаг, хөгжлийн яамны хамтарсан НЗДТГ, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгмэлэг (GIZ) хамтран хэрэгжүүлж буй “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага” сургалтад Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Ц.Бямбасүрэн, Байгууллагын дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхзул, Төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан эдийн засагч Х.Дэлгээнбаяр нар 2 сарын сертификаттай цахим сургалтад хамрагдсан.<br><br>2.Мөн Швейцарийн хөгжлийн агентлаг, ХБНГУ-ын Холбоны эдийн засаг, хөгжлийн яамны хамтарсан НЗДТГ, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгмэлэг (GIZ) хамтран хэрэгжүүлж буй “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулсан “Жендэрийн мэдрэмжтэй төрийн алба”, “ Хүний нөөцийн бодлог дахт жендэрийн асуудлууд”, Жендэрийн мэдрэмжтэй орчин бүрдүүлэх”, Жендэрийн мэдрэмжтэй удирдлага”, “Жендэрийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээг хүргэх нь” Хүний нөөцийн мэргэжилтэн сертификаттай сургалтад хамрагдсан;<br>3. Covid-19 холбоотой ZOOM-аар Орос улс, БНСолонгос улсын туршлага солилцох сургалтад Орлогч дарга, Тооцооны нягтлан бодогч, Тээвэр зохицуулагч нар хамрагдсан. |
| | 2 | Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх | 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | 70 хувь | 90 хувь | 70 хувиас дээш | Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтад Ахлах нягтлан бодогч Мэргэшсэн удирдлагын нягтлан бодогчийн хязгааргүй эрх авах сургалтад хамрагдаж үнэмлэхээ авсан.<br>Мөн мэргэшсэн жолоочийн мэргэжлийн үнэмлэхээ авсан 4 албан хаагч амжилттай ажиллаж байна.<br>Мэргэшсэн албан хаагчдын эзлэх хувь 88.9% байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хэсгийн дундаж: | | | | | | 100 хувь |
| 2.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | 3 | Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Шагнал урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо | Гүйцэтгэлээр | Нийт албан хаагч | | 1.Байгууллагын ажлын үр дүн тооцон албан хаагчдыг шагнаж урамшуулахаар ажлын үр дүн, гүйцэтгэлийг сар бүр дүгнэн шагнаж, урамшуулан ажиллаж байна.<br>2.Covid-19 –ийн талаарх мэдээлэл ард иргэдэд өгч ажилласан нийт албан хаагчдыг I, II, III, IV улиралд урамшуулсан болно.<br>3.Хяналт шалгалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч Х.Нарангэрэл, Техникч Ж.Мөнхбат Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулсан.<br>4.Байгууллагын 2020 оны ажлын үр дүнг үнэлж “Хүндэт өргөмжлөл”, “Оны шилдэг”, “Өргөмжлөл” –д албан хаагчдын аж лыг үнэлж, урамшуулсан.<br>/Хэрэгжилт 100 хувь/ |
| | | | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах | Гүйцэтгэлээр | 100 хувь | 380 сая | 1.Байгууллагын албан хаагчдын цаг ашиглалт, ажлын байрны дэг журамд тогтмол хяналт тавин, цалин урамшуулал олгоход ажлын цагийн ашиглалт, ажлын гүйцэтгэлийг тооцон ур чадварын нэмэгдлийг сар бүр, үр дүнгийн урамшуулалыг улирал бүр олгон ажиллаж байна.<br>2.Байгууллагын даргын Б/54 дүгээр тушаалаар төрийн албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэл, Б/92 тушаалаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, мэргэшсэн зэргийн нэмэгдэл 12 албан хаагчдад олгон ажиллаж байна.<br>3.Олон жил ажилласан туршлагатай албан хаагчийг байгууллага дотроо шилжүүлэн ажиллуулж, хэлтэс алба хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, албан хаагчийг урамшуулах бодлого барин Б/88, Б/89 тушаалаар албан тушаал ахиулан ажиллаж байна<br>4.Оны эцсийн байдлаар нийт албан хаагчдын 98.8 хувьд нь хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчийн зэрэг дэвийн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, мэргэшлийн зэргийг нэмэгдэл зэрэг бусад нэмэгдэл цалин хөлсийг тухай бүр шинэчлэн олгож, 94 албан хаагч ямар нэгэн нэмэгдэл авч байна.<br>5. Мөн тайлант хугацаанд 22 албан хаагчдад 6,150,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлснээс 6 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах эрх нь үүсч 116.805.699 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгож ажиллалаа. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 6.Сар шинийн болон ахмадын баяраар 96 нийт ахмадуудад хүндэтгэл үзүүлж 2020 оны 02 дугаар сарын А/16 дугаар тушаалаар 2,85 сая төгрөг, 2020 оны 09 дүгээр сарын 16-ны А/64 дугаар тушаалаар - 2,92 сая төгрөг нийт 5,770,000 төгрөг олгосон байна<br>7. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2020 оны 05 дугаар сарын 21-ны А/45 дугаар тушаалаар албан хаагдын 0-16 насны 81 хүүхдэд 3.5 сая төгрөгийн бэлэг өгсөн /Хэрэгжилт 100 хувь/ |
| | 4 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга | Сэтгэл ханамж 80 хувиас дээш | 94 хувь | 6,2 сая | 1.Албан хаагчдын ажлын хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, бичиг хэрэг ажлын багаж хувцас хэрэгслээр ханган ажиллаж байна. Ажлын байрны эмх цэгц, аюулгүй байдалд анхаарч өрөө тасалгааны гэрэлтүүлгийг сайжруулж, хана таазыг эмульсдэж, бусад жижиг засварыг хийж албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.<br><br>2.Коронавирус гарсантай холбоотойгоор ажлын байрны ариутгал, цэвэрлэгээний материал болон ААН, албан хаагчдад амны хаалтыг өдөрт 2ш тогтмол өгч хэвшсэн. |
| | | | Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх | Гүйцэт гэлээр | 100 хувь | 90.2 сая | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар тавьсан зорилтын хүрээнд нийт цалинд-656,2 сая төгрөг, ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалд нийт 103.6 сая, албан хаагчдын хоол унааны зардалд 45,5 сая төгрөг, ажлын хувцас, хэрэгсэлд -5,6 сая төгрөг, хүүхдийн баяр-3,5 сая, нэг удаагийн буцалтгүй тусламжийг 6 удаагийн тушаалаар 1,650 төгрөг, цалинтай чөлөө- 29 албан хаагчид тушаалаар олгож, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зориулсан байна. |
| | 5 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг | Жилд 1-ээс доошгүй удаа | 100 хувь | 4.8 сая | 1.Тус газар нь албан хаагчдыг Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулан ажилладаг./Үзлэгт хамрагдаагүй/<br>2.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах Шинэ төрлийн коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх мөн бусад өвчлөлөөс хамгаалах зорилгоор урьдчилан сэргийлж, өглөө бүр тогтмол халуун үзэж, тэмдэглэл хөтлөж байна.<br>3.Албан хаагчдын хэрэгцээнд эмийн сан, ариутгалын бодис, амны хаалт, цэвэрлэгээний бодис авахад – 4.8 сая төгрөг зарцуулан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтмол хийж байна. Шинжилгээ өгөөгүй албан хаагчдыг харьяа хороо дүүрэгтээ шинжилгээгээ өгөхийг уриалан ажиллаж байна.<br>5.Албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт наадмын цасны баярт хамруулж 850,4 мянган төгрөг зарцуулсан.<br>6. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нийслэлийн Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн төвөөс Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх зөвлөмж, заавар, мэдээ мэдээллийг албан хаагчдад тогтмол хүргэн танилцуулж байна |
| | | | Албан хаагчдын хамрагдалт | 100 хувь | 100 хувь | - | 100 хувь |
| | Хэсгийн дундаж: | | | | | 100 хувь | 100 хувь |
| Үнэлгээний дундаж хувь: | | | | | | 99.7 хувь | 99.7 хувь |

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.САЙХАНБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.МӨНХБАЯР

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН О.РЭНЦЭНХАНД